



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албаны тусгай
үүргийн бэлтгэл шатны сургалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын хавсралт 4.1, 4.2, 4.6 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1250 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2025 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлага олгох тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Налайх дүүргийн Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн байрлалд сургалтыг зохион байгуулсугай.

2.Сургалтад хамрагдах цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтыг хариуцлагатай зохион байгуулж, хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

4.Шаардагдах 3,282,000 (гурван сая хоёр зуун наян хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 19 ны өдрийн
8/19 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



СУРГАЛДТАД ХАМРАГДАХ ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР
ДҮЙЦҮҮЛЭН ХААГЧ ИРГЭДИЙН НЭРИЙН
ЖАГСААЛТ

№	Овог нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг
1	Баттулга Анхбаяр	УФ06210616	1-р хороо 4-54 тоот
2	Батбаатар Амгаланбилэгт	УФ04261413	1-р хороо 2-06 тоот
3	Цэрэндаш Дашням	НС04222217	2-р хороо 14-06 тоот
4	Өлзийсайхан Мөнх-Эрмүүн	УФ05270515	1-р хороо 3-05 тоот
5	Энхтөр Отгонхүү	ОП04282118	1-р хороо алтгана 1-06 тоот
6	Анхныбаяр Наранбаяр	УФ03261898	1-р хороо 4-54 тоот

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 17 ны өдрийн
01195 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ СУРГАЛТАД
ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Гэрчилгээ	ш	6	30,000	180,000
2	Хоол	14 хоног	6 хүн	36,000	3,024,000
3	Шатахуун	л	40	1950	78,000
	Дүн				3,282,000